



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/140/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр:  
Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг  
Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Н.Отгонцэцэг  
Утас: 70373089 Цахим хаяг: otgontsetsegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

40008 Дархан-Уул аймаг  
Дархан сум, 14-р баг  
Төв, 7007-5088, 4400 (810) 7007-5088  
E-mail: darhanuul@audit.gov.mn

Хугацаа: 2021.09.14 № 105  
Тайлбар: -ийн № -ийг

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

ШУТИС-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц БАТБААТАР ТАНАА



**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заарын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохиистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгслэлчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009020039

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	539,559.8	453,694.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,523,290.6	16,780,627.7
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>17,062,850.4</b>	<b>17,234,321.8</b>
	Нийт өр төлбөрийн дүн	418,112.1	385,092.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	16,644,738.3	16,849,229.8
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>17,062,850.4</b>	<b>17,234,321.8</b>
<b>Үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,625,065.0	6,512,384.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	5,904,189.2	6,222,978.2
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(279,124.2)</b>	<b>289,406.1</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>(279,124.2)</b>	<b>289,406.1</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,874,862.5	16,644,738.3
	ҮХДҮ-ний өсөлт бууралт	49,000.0	(84,914.5)
	Тайлант оны үр дүн	(279,124.2)	289,406.0
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>16,644,738.3</b>	<b>16,849,229.8</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	5,495,594.6	5,892,497.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	5,416,892.5	5,849,727.6
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>78,702.1</b>	<b>42,769.7</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(53,348.5)</b>	<b>(46,720.1)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>		-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>25,353.6</b>	<b>(3,950.5)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	91,222.3	116,575.9
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>116,575.9</b>	<b>112,625.4</b>
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>5,356,121.2</b>	<b>5,772,521.5</b>
	Урсгал зардал	5,356,121.2	5,772,521.5
	Хөрөнгийн зардал		-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>5,381,474.8</b>	<b>5,772,521.5</b>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,185.5	
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	5,314,289.3	5,772,521.5

## **Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль нь дээд боловсрол олгодог, эрдэм шинжилгээ судалгааны үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

## **Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд мөнгөн гүйлгээний тайлангаар нийт орлого 5,892,497.3 мянган төгрөгөөр бүртгэгдсэний 46.1 хувь буюу 2,718,660.3 мянган төгрөгийг сургууль хоорондын тооцоогоорх орлого эзэлж байна. Сургалтын төлбөрийн орлогыг төв сургуульд төвлөрүүлж, зардлыг санхүүжүүлж байгаа нь орлого, зардлын дүнг бодит бусаар өсгөн санхүүгийн тайланд тусган харуулж байна.

## **Дөрөв. Аудитын гол асуудал**

ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

## **Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Тайлант хугацаанд нь шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллийг хугацаанд нь оруулсан боловч 131,151.2 мянган төгрөгийн 4 мэдээллийг оруулаагүй байсныг аудитын явцад шилэн дансанд байршуулан залрууллаа.

## **Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## **Долоо. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 131,968.1 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс, 131,151.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулан, 816.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### **Залруулсан алдаа**

Шилэн дансны сайтад 131,151.2 мянган төгрөгийн 4 мэдээллийг аудитын явцад залруулсан.

### **Төлбөрийн акт**

Тус байгууллагын багш Ч.Сугаррагчаагийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 816.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон тул төлбөрийн акт тогтоолоо.

## 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
<b>НИЙТ</b>									

## 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс /сая төгрөгөөр/							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	1	816.9			1	816.9				
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	1	131,151.2	1	131,151.2						
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн										
<b>НИЙТ ДҮН</b>		<b>2</b>	<b>131,968.1</b>	<b>1</b>	<b>131,151.2</b>	<b>1</b>	<b>816.9</b>				